

ДАРХАН СУМЫН 2024 ОНЫ ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ТАЙЛАН

2024.01.21

Дархан-Уул аймаг

Дархан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 20 дугаартай "Сумын 2024 оны төсөв батлах тухай" тогтоол, 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 06 дугаартай "Сумын 2024 оны төсөвт зохицуулалт хийх тухай" тогтоол, 2024 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 07 дугаартай "Сумын 2024 оны төсөвт тодотгол хийх тухай" тогтоолоор тус тус 2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн шилжих хөрөнгө оруулалт, шинээр эхлэх хөрөнгө оруулалтын дүнг баталсан.

Дархан сумын 2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 4,621,664.5 мянган төгрөгийн санхүүжих дүнтэй 77 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр батлагдсанаас шилжих хөрөнгө оруулалтаар 678,554.8 мянган төгрөгийн 12 төсөл, арга хэмжээ, шинээр эхлэх хөрөнгө оруулалт 3,933,109.7 мянган төгрөгийн 64 төсөл, арга хэмжээ, Малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгөөр санхүүжүүлэх 10,000.0 мянган төгрөгийн 1 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр батлагдсан.

2024 онд тус сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих нийт 3.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 12 тендер шалгаруулалтыг амжилттай зохион байгуулж, ажил гүйцэтгэх гэрээг байгуулан, хэрэгжилтийг ханган ажилласан.

2024 онд санхүүжүүлэхээр шилжих хөрөнгө оруулалтад тусгагдсан Бараат хогийн цэгийн цахилгаан татах ажлын чанарын баталгаа 3,776.0 мянган төгрөг, Инженерийн хийцтэй ухаалаг худаг /3, 8, 15, Малчин баг/ ажлын чанарын баталгаа 20,000.0 мянган төгрөг, Орон сууцны хороолол доторх авто зогсоол /13, Өргөө баг/ ажлын чанарын баталгаа 2,230.0 мянган төгрөг, Сайжруулсан шороог зам засварын ажил /3 дугаар баг/ 2,089.2 мянган төгрөг, Авто зам, зогсоолын хүчитгэлийн ажил 7,157.5 мянган төгрөг, Тоглоомын талбайн тохижилт /10 дугаар баг/ 2,000.0 мянган төгрөг, Авто зам, зогсоолын засвар шинэчлэл 120,980.6 мянган төгрөг, Авто замын засвар /Өргөө баг/ 180,965.4 мянган төгрөг, Авто зогсоол /4, 13 дугаар баг/ 242,526.1 мянган төгрөг, Авто зогсоолын засвар /14 дүгээр баг, 39-р байр/ 17,900.9 мянган төгрөг, Ногоон байгууламж, засвар, арчлалт 14,140.0 мянган төгрөг, Авто замын давхар хучилтын ажил 5,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон.

2024 онд шинээр эхлэх хөрөнгө оруулалтад тусгагдсан 65 төсөл, арга хэмжээний 3,762,477.9 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон.

4 дүгээр багт хэрэгжиж буй Мөнхнайрамдал талбайн гадна тохижилтын ажил 80%, олгогдсон санхүүжилт 80%, 10 дугаар багт хэрэгжиж буй Нийтийн орон сууцны орц засварын ажил 30%-ийн гүйцэтгэлтэйгээр дараа онд шилжин хэрэгжихээр 2025 оны төсөвт тусгагдсан байна.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

Дархан сумын Засаг даргын Тамгын газрын
Төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалт хариуцсан
мэргэжилтэн



Б.Ундрах